

“МОНГОЛЫН НУУЦ ТОВЧОО” СУДЛАЛЫН ШИНЭ ХАНДЛАГА

Ёшида Жүн-Ичи

Товч утга: Монголын эзэнт гүрний үеийн түүхийн үндсэн сурвалж бол “Монголын нууц товчоо”, “Богд баатар биеэр дайлсан тэмдэглэл”, “Юань улсын судар”, Рашид-ад-дины “Судрын чуулган” зэрэг билээ. Эдгээр сурвалжийн агуулга, хоорондынхолбоо харьцаа, агуулгыг нарийвчлан харьцуулж үзэх нь Монголын эзэнт гүрний үеийн түүхийн судалгаанд зайлшгүй шаардлагатай. Үүнд, “Монголын нууц товчоо” нь бусад 3 сурвалжаас нэлээд зөрүүтэй, бүр бүтцийн хувьд өөр бөгөөд үүний шалтгаан нь сурвалжуудыг бичихэд харилцан адилгүй сурвалж хэрэглэгдэхүүн ашигласанд бус, харин “Монголын нууц товчоо”-ны зохиогчийн үзэл санаатай холбогдоно.

Түлхүүр үг: “Монголын нууц товчоо”, “Судрын чуулган”, “Богд баатар биеэр дайлсан тэмдэглэл”, “Юань улсын судар”, зохиогчийн үзэл.

Өмнөх үг: “Монголын нууц товчоо”-ны тухай

“Монголын нууц товчоо *Mongγol-un ni'ūca tobčīyan*” (цаашид “Нууц товчоо” гэж товчилно) нь Чингис хааны өвөг дээдэс (1-52-р зүйл), Чингис(Тайзу) хааны амьдрал (53-268-р бүлэг), Өгөдэй (Тайзон) хааны засаглал (269-282-р зүйл)-ын тухай Монголын эзэнт гүрний үед монгол хэлээр бичигдсэн сурвалж билээ. Мин гүрний эхэн үед “Нууц товчоо”-ны эхийн монгол хэлний дуудлагыг ханз үсгээр илэрхийлж, үг тус бүрийн утгыг хятадаар тайлбарлан хажууд нь хаджээ (хадмал орчуулга гэж нэрлэдэг). Жишээ нь, Чингис хааны нэр болох Тэмүжин (Temüjin) гэдэг үгийг “帖木真” хэмээн ханз үсгийн дуудлагаар илэрхийлж, “хүний нэр” хэмээх хадмал орчуулга хийжээ. Тус сурвалж нь нийт 282 зүйлээс бүрдэх бөгөөд 12 буюу 15 дэвтрээр бидний үед уламжлагдан иржээ. Хятадаар “Юан гүрний нууц түүх 元朝秘史” хэмээн нэрлэснийг монголоор “*Mongγol-un ni'ūca tobčīyan* (Монголын нууц товчоо)” хэмээдэг¹.

1. “Нууц товчоо”-ны 2-р мөрний “*Činggis qahan-u huja'ur* (Чингис хааны язгуур)” гэдэг үг нь 3-р мөрний “*de'ere tenggeri-eče jaya'tu töregsen börte čino aju'u* (дээр тэнгэрээс заяат төрсөн бөрт чоно ажээ)” гэсэн өгүүлбэрийн үйлийн эзэн буюу өгүүлэхүүн юм. [Damdin-

“Нууц товчоо” нь “Шибу-цонкан эмхэтгэл” (四部叢刊)-д 12 дэвтрээр (Үндсэн хэсэг 10 дэвтэр, Нэмж зохиосон 2 дэвтэр), “Юнлө хааны хууль зүйлийн бичиг”(永樂大典)-г 15 дэвтрээр орсон байдаг.²

Тус зохиолын “Нууц түүх” гэсэн нэрнээс үүдэж түүхийг эмхэлэн бичсэн зохиол гэж үзэх явдал буй боловч угтаа он дараалалын бичиг бус болно [Yoshida 1968]. Мөн шүлэглэн өгүүлсэн хэсэг олон боловч баатарлаг тууль ч бус [Владимирцов 1934]. Сонирхол татахуйц үйл явдлуудыг дүрслэн өгүүлсэн уран зохиолын шинж чанартай болгохын тулд баримтыг өөрчлөхөөс эс буцах нэр нь үл мэдэгдэх зохиогчийн зохиол гэж үзэх [Okada 1970] судлаачийн саналтай нийцэх хэсэг ч уг зохиолд буй.

“Нууц товчоо” судлалд “Шибу-цонкан эмхэтгэл”-д орсон эхийг голлон хэрэглэдэг. “Нууц товчоо”-ны агуулгыг зөв ойлгож, зүүлт тайлбарыг үйлдэхийн тулд эхлээд галиглах буюу монгол хэлээр буулгасны үндсэн дээр орчуулах хэрэгтэй болно. Тийнхүү галиглаж, орчуулсан нь Хэниш, Пэллио, Рахэвилц, Баяр, Озава, Арджав нар болно. [Haenisch 1935; Haenisch 1941; Pelliot 1949³; Rachewilts 1972; Rachewilts 2004; Bayar 1981; Ozawa 1984-1989; Ozawa 1997; Ardaĭab 2005⁴].

Мөн Хаттори бээр “Нууц товчоо”-ны ханз үсгийн Мингийн эхэн үеийн дуудлагыг хамгийн анх судалжээ [Hattori 1946]. Дээр дурдсан галиг болон орчуулгын үр дүнг тусгасан судлаач нарт Хэниш, Ширатори, Лигэти, Дашцэдэн, Ринчин, Күрибаяши, Чойжинжав нарыг дурдаж болно [Haenisch 1935; Shiratori 1943; Ligeti 1971; Дашцэдэн 1985; Irinčin 1987; Kuribayashi, Šoyijinjab 2001].

“Нууц товчоо”-ны орчуулгыг Нака, Кобаяши, Мүраками, Озава нар япон [Naka 1907; Kobayashi 1941; Murakami 1970-1976; Ozawa 1984-1989; Ozawa 1997], Жагчидсэцэн нар хятад [Jaγcidsečen 1979; Dorunatib 1979], Хэниш нар герман [Haenisch 1941], Кливз нарын англи [Cleavs 1982; Rachewilts 2004], Козин нар орос [Козин 1941] хэлээр орчуулсан билээ.

-
- sürüng 1947; Haenisch 1948; Pelliot 1949; Jaγcidsečen 1979; Bayar 1981; Heissig 1981; Irinčin 1987; Šeringsodnam 1993; Ozawa 1984-1989; Ozawa 1994; Ozawa 1997]. Үүнийг зохиолын нэр гэж ойлгон, дараагийн өгүүлбэрийг ”.....бөрт чоно ажгуу” гэж орчуулсан [Naka 1907; Mostaert 1953; Kobayashi 1954; Murakami 1970-1976; Rachewilts 2004] нь буруу юм.
2. Энэ 2 эхэд Е Дэхүй (葉德輝)-гийн хэвлүүлсэн “Нууц товчоо” (12 дэвтэр)-г нэмж гэрэл зургаар хэвлэсэн [Yuanchao mishi 1975], бас зөвхөн “Юнлө хааны хууль зүйлийн бичиг”-ийн эхийн гэрэл зургын хэвлэл буй [Панкратова 1962]. “Нууц товчоо”-ны гар бичмэл, эхүүдийг сайтар хянан үзсэн “Нууц товчоо” судлалын суурь судалгаа ч буй [Eldengtei, Oyundalai 1980; Ulayaᠨ 2012].
 3. Галиг ба франц хэлний орчуулгаас бүрдэх авч орчуулга нь 8-р ботийн төгсгөл 185-р зүйл хүртэл болно.
 4. [Ardaĭab 2005] нь [Eldengtei, Oyundalai 1980] [Eldengtei, Oyundalai, Asaraltu 1980] [Eldengtei, Ardaĭab 1986] –г галиг нэмж хийн хэвлүүлсэн.

Харин Дамдинсүрэн, Элдэнтэй, Ардажав, Цэрэнсодном нар орчин цагийн монгол хэл болон монгол бичгээр буулгажээ [Damdinsürün 1947⁵; Eldengtei, Ardaĵab 1986; Īeringsodnam 1993].

“Нууц товчоо”-ны орчуулга, галиг нь тайлбар ихтэй, үндсэн эхийн орчуулгаас зүүлт тайлбар нь илүү зай эзэлсэн судалгаа ч байдаг. Тэрхүү зүүлт тайлбар нь “Нууц товчоо” судлалд ихээхэн чухал билээ. Түүнээс гадна “Нууц товчоо”-ны үгийн сан, өгүүлбэрийн утга, “Нууц товчоо” зохиолыг судалсан судалгаа, ном зохиол ч буй. Үүнд, Мостаэрт, Озава, Поуха, Элдэнтэй, Оюундалай, Аспалт, Jingkin, Ёшида, Чоймаа нарыг дурдаж болно [Mostaert 1953; Ozawa 1954; Poucha 1956; Eldengtei, Ardaĵab, Asaraltu 1980; Jingkin 1991; Ozawa 1993a; 1993b; Yosida 2005; Īoyim-a 2007].

“Нууц товчоо”-г судалсан судалгаа ер цөөн бус боловч Монгол улсад 1991 онд социалист тогтолцоо нурж, Хятадад “соёлын хувьсгал” дуусгавар болсоноос хойш судалгаа эрчимжиж эдүгээ тэр бүхнийг гүйцэж мэдэхэд бэрх хэмжээнд хүрэв.

Урьд Японд “Нууц товчоо”-нд холбогдох ном зүй [Harayama 1978] хэвлэгдсэн авч одоо бол Нууц товчооны орчуулга болох [Rachewilts 2004]-ийн ном зүйг давхар үзвэл дөхөм болно.

“Нууц товчоо”-ны үндсэн эх бичигдсэн оны тухайд, 282-р зүйлийн төгсгөлийн үгэнд “Их хуралдай хуралдаж, хулгана жилийн долдугаар сард Хэрлэн голын Хөдөө арал (Köde'e aral)-д орд бууж байхад бичиж дуусгав” гэж буй. Энэ нь чухам хэдэн он болох талаар судлаачид, “Өгэдэй хааныг хаан ширээнд суухын өмнөх жил болох 1228 он [Din 1901; Uemura 1955; Ishihama 1935; Kobayashi 1954; Rachewilts 1965; Irinĉin 1987; Jingkin 1991 бусад], “Өгэдэй хааныг нас барахын өмнөх жил болох 1240 он” [Палладий 1866; Li 1896; Pelliot 1949; Козин 1941; Haenisch 1948; Бира 1978 бусад], 1252 он [Grousset 1941; Yu 1982], 1264 он [Hung 1951 бусад], 1276 он [Yao, Jaŷidseĉen 1960-1962 бусад], 1324 он [Окада 1985] зэрэг олон санал дэвшүүлжээ. Японы судлаач Накагийн тухайд 1240 оныг дэмжигч гэгддэг боловч, тэрээр “Нууц товчоо” нь Чингис (Тайзу) хааны үед зохиогдож, нэмэлт хэсгийг Өгөдэй (Тайзон) хааны 12 онд бичсэн гэж үзсэн [Naka 1907] байдаг тул 1240 он гэсэн саналыг баримтлагч биш юм. Энэ мэт зөрөөтэй саналууд гарах болсон нь 1228 оны хулгана жилээс хойшх явдлыг “Нууц товчоо”-ны “Нэмэлт хэсэг”-т тэмдэглэсэнтэй холбогдоно. Энэ тухайд, 1228 онд бичсэн үндсэн хэсэг болон хожим нэмсэн хэсгээс бүрдэх бөгөөд төгсгөлийн үг нь эхний хэсгийн төгсгөлд байсан боловч нэмэлт хэсгийг бичихдээ хамгийн сүүлд оруулсан гэж үздэг [Uemura⁶; Ishihama 1935].

5. Энэ хөрвүүлэг хожим кирилл үсгээр, хэд хэдэн удаа хэвлэгдсэн.

6. Үэмүрагийн илтгэл “Монголын нууц товчооны төгсгөлийн үгийн тухай асуудал” Шигаку зашии 史学雜誌 (Түүх судлал сэтгүүл) 42-7, 1931 ба 1931 онд Кобаяшид явуулсан захидалд үндэслэв [Kobayashi 1954].

Гэхдээ эхний хэсгийн аль хүртэлхийг 1228 онд бичсэн талаар олон санал гарчээ⁷. Харин 1252 онд нэг дор бичиж дуусгасан хэмээх санал ч буй [Hung 1951].

Озава бээр “Нууц товчоо”-ны төгсгөлийн үгийн хулгана жил нь 1228 (шар хулгана), 1252 (хар хулгана) оныг давхар зааж буй тул төгсгөлийн үгийг нэмэлт хэсгийн төгсгөлд шилжүүлээгүй хэмээн үзэв. Түүнчлэн үндсэн хэсэгт улс орны дотоод түүх, нэмэлт хэсэгт эзэнт гүрний гадагшаа хийсэн байлдан дагуулалтын тухай тэмдэглэсэн, тийнхүү агуулгын хувьд тодорхой ялгаатайтай учир үндсэн хэсгийн сүүлд төгсгөлийн үг байх нь тохиромжтой, нөгөө талаар Чингис хааны үхлийн тухай өгүүлсэн 268-р зүйл нь [Damdinsürin 1947], [Төмөрцэрэн 1990] нарын цохон тэмдэглэсэнчлэн авцалдаа муутай тул төгсгөлийн үг байсан гэж үзэхэд бэрх хэмээн үзжээ [Ozawa 1994]. “Нууц товчоо”-ны уг эхийг нэг дор биш хоёр үе шатыг дамжин бичигдсэн гэж олонх судлаачид үзэж байна.

“Нууц товчоо”-ны зохиогчийн хувьд Чингисийн гэр бүлийхэний талд зогсвоос зохих хүн [Ozawa 1994] бөгөөд хятадаар орчуулсан оны тухайд Мин улсын эхэн үе гэж үзэх нь нийтлэг мэт.

Мөн ханзны дуудлагаар “Нууц товчоо”-г хэдийд тэмдэглэсэн, эдүгээ буй эхүүд хэрхэн уламжлагдаж ирсэн, хоорондоо ямар холбоотой болох тухайд, олон судалгаа гарсан тул [Hung 1951; Kobayashi 1954; Jen 1986; Ozawa 1994; Temürbayan-a 2004; Temürbayan-a 2009; Ulayan 2012 зэрэг] энд үл нуршина.

1. “Нууц товчоо”, “Судрын чуулган” зэрэг 3 эх сурвалжийн харьцааны тухай

“Нууц товчоо”-ноос гадна тухайн үеийн үндсэн сурвалжид “Богд баатар биеэр дайлсан тэмдэглэл” (цаашид “Тэмдэглэл” хэмээнэ), “Юань улсын судар”, Рашид-ад динь “Судрын чуулган” (цаашид энэ 3 тулгар бичгийг “Судрын чуулган” зэрэг 3 сурвалж, “Нууц товчоо”-г оролцуулан эдгээр 4 эх сурвалж бичигт Чингисийн амьдралыг өгүүлсэн хэсгийг “Чингисийн шастир” хэмээн товчилно). Эдгээр сурвалж бичиг тус бүрийн агуулга, хоорондын холбоо, агуулгыг нарийвчлан харьцуулж үзэх нь Монголын эзэнт гүрний үеийн түүхийн судалгаанд зайлшгүй шаардлагатай төдийгүй “Нууц товчоо”-г ойлгож мэдэхэд чухал болно.

Дээрх 4 сурвалжийн хоорондын хамаарлыг Нака [Naka 1907], Амбис [Pelliot, Hambis 1951], Хун [Hung 1951], Кобаяши [Kobayashi 1954], Бира [Бира 1978], Ринчин [Irinčin 1987] нар судалжээ. Тэдний үзлийг товч дурдвал,

7. Чингисийг нас барсан тухай тэмдэглэсэн 268-р зүйл хүртэл (Рахэвилц 2004; Иринчин 1987; Жинкин 1991), үндсэн хэсгийн 10-р дэвтрийн сүүл (246-р зүйл) хүртэл (Uemura 1955), үндсэн хэсгийн 10-р дэвтрийн төгсгөл орчим хүртэл (Кобаяши 1954) гэх зэрэг санал буй.

Юань улсын Дотоод ордонд хадгалагдаж, гадны этгээд үзэж танилцах боломжгүй байсан уг эх “Товчоон (Tobčiyān)”-ы тухайд, М.Нака бээр “Монголын нууц товчоо” (Mongyol-un ni’uša tobčiyān)-ны хураангуйлсан нэр, Кобаяши болбаас “Судрын чуулган”-нд дурдагдах “Алтан дэвтэр”-тэй гарал нэгтэй, Бира абугай “Нууц товчоо”-той адилтгаж болох эх бөгөөд үүнийг Персэд “Алтан дэвтэр” хэмээн нэрлэж байсан бололтой, Iginčin бээр “Монголын нууц товчоо”-ны анхны нэр, бас “Судрын чуулган” зэрэг 3 сурвалж нь засаж бичсэн Tobčiyān-ноос гаралтай хэмээн үзсэн байдаг. Мөн Бира Tobčiyān-ыг үндсэн сурвалж мөн гэв [Нака 1907; Kobayashi 1954; Бира 1978; Iginčin 1987]⁸ Өөрөөр хэлбэл, ихэнх судлаачид “Нууц товчоо” “Судрын чуулган” зэрэг 3 сурвалжийн үндсэн эх хэмээн үзсэн гэж хэлж болно. Эндээс үзвэл, “Нууц товчоо”-г сурвалжийн хувьд онцгой байр суурь эзлэхийг хүлээн зөвшөөрч ирсэн нь харагдана.

Судлаач Хун үзэхдээ, анх “Činggis Qahan-u huja’ur” гэж байгаад хожим Мин улсын эхэн үед дуудлага тэмдэглэн, орчуулагдсанаар “Нууц товчоо” буй болж, “Судрын чуулган” зэрэг 3 сурвалж нь “Činggis Qahan-u huja’ur” дээр баримт материал нэмсэнээр тус тус буй болсон гэжээ.⁹ Мөн Tobčiyān гэдэг нь “Тайзу хааны магад хууль”, “Тайзон хааны магад хууль”-ийн монгол хэлээрх хувилбар бөгөөд түүнийг эмхэтгэгч нь “Činggis Qahan-u huja’ur”-ыг чөлөөтэй үзэж болох эх сурвалжийн хувиар олонтаа эшилж, түүний агуулгыг хасч өөрчлөх зэргээр дахин эмхэтгэсэн хэмээн үзсэн. Түүнчлэн “Алтан дэвтэр”-ийг Ил хааны улсад зориулж “Tobčiyān”-нд үндэслэн бичсэн хэмээх санал дэвшүүлсэн байна. Чингэхдээ, Хун бээр “Činggis Qahan-u huja’ur” нь “Нууц товчоо”-ны өмнөх үг эсвэл дэд сэдэв, зохиолын нэр аль нь болох нь тодорхойгүй гэсэн авч тийнхүү “Нууц товчоо”-той адилтган үзэж, “Судрын чуулган” зэрэг 3 сурвалжийг эмхэтгэхэд ашигласан анхны сурвалж хэрэглэгдэхүүн гэж дүгнэжээ [Hung 1951]. Энэ асуудлын тухайд, дээр дурдсан бусад судлаач нартай онцын ялгаа үгүй гэж хэлж болно.

Миний бие урьд дээрх 4 сурвалжийн агуулгыг судалж, тэдгээр дэх “Чингисийн шастир”-т төстэй зүйл олон авч нэг бүрчлэн уншихад “Судрын чуулган” зэрэг 3 сурвалжийн хоорондох зөрүү төдий л их бус атал “Нууц

8. Кобаяши абугай, “Тэмдэглэл”-ийн “болсон явдлыг хөндлөнгийн байр сууринаас өгүүлсэн нь Рашид ад дин-тай төстэй” хэмээгээд, тэр нь “Рашид-ад динь ашигласан дорно зүгийн сурвалж бичгийн нэг төрөл болон эх бичмэлтэй нэгэн адил” гэжээ [Kobayashi 1954: 150]. Кобаяшигийн гаргалгааны үндэслэл болсон “Тэмдэглэл” болон “Судрын чуулган”-ы төстэй болон ялгаатай талын талаарх үзэл бодолд ташаарсан зүйл олон.

9. Амбис “Судрын чуулган” зэрэг 3 сурвалжийн эх хэрэглэгдэхүүнийг “Алтан дэвтэр”-тэй холбогдоно гэсэн авч “Нууц товчооны” эх хэрэглэгдэхүүнтэй холбооны дурдсангүй [Pelliot, Hambis 1951]. Рахэвилц “Нууц товчоо” болон “Судрын чуулган” зэрэг 3 сурвалжийн холбооны тухай бараг дурдсангүй [Rachewilts 2004]. Харин “Алтан дэвтэр”-ийн талаарх шинэ судалгааны хувьд, миний [Yoshida 1984] 4-р зүйлд дурдсан судалгааг нэмж зассан [Yosida 2005] бий.

товчоо”-той нэлээд зөрүүтэй, бүр бүтцийн хувьд өөр болохыг олж мэдэв. Учир нь ”Чингисийн шастир” дахь Чингис болон Монголын эзэнт гүрний бусад бүлэглэл (аймаг, улс) хоорондын харилцааг ”Нууц товчоо”-нд, Монголын эзэнт гүрэн байгуулагдахын өмнөх болон дараах үйл явдлыг нэгэн адил богино цаг хугацаанд төвлөрүүлэн дараа дараагаар өрнөж өнгөрсөн бүлэг үйл явдал, тэрхүү үйл явдал тус бүрийн хамаарлыг их төлөв он цагийн дарааллаар байрлуулсан байна. Үүнтэй харьцуулахад, “Судрын чуулган” зэрэг 3 сурвалжид бол бусадтайх харьцааг дурдахын зэрэгцээ үйл явдлууд нь тодорхой зай бүхий хэдэн жилийн турш болж өнгөрсөнөөр өгүүлсэн учраас тийнхүү үзсэн болно. Тийм учраас “Судрын чуулган” зэрэг 3 сурвалжийг нэг төрлийн буюу ойр сурвалжид тулгуурлан зохиосон, харин ”Нууц товчоо”-ны хувьд тийм бус, тухайн үеийн үлгэр түүхийг өгүүлэгч этгээд бүлэглэл хоорондын харьцааг цээжилж ярихад хялбар, нэгтгэсэн байдлаар ярьж үлдээснийг эмхэтгэгч нэгтгэн цуглуулж он тооллын дарааллаар байрлуулан холбож, хэд хэдэн газар уран дүрслэл нэмж оруулсанаар бидний мэдэх “Нууц товчоо” буй болсон хэмээх санал дэвшүүлсэн билээ¹⁰.

Гэвч сүүлийн жилүүдэд дээрх 4 сурвалж дахь “Чингисийн шастир”-ыг эмхэтгэхэд ашигласан хэрэглэгдэхүүний тухайд дахин судлах шаардлагатайг мэдэрч, “Нууц товчоо”-г болон “Судрын чуулган” зэрэг 3 сурвалжийг эмхэтгэхэд ашигласан сурвалж хэрэглэгдэхүүн нэг гаралтай, үгүйдээ адил бус авч “Нууц товчоо”-ны агуулгаас харагдах хэмжээний ялгаатай бус байсан болов уу гэж үзэв [Yoshida 2009a]. Өөрөөр хэлбэл, ”Нууц товчоо”-г эмхэтгэгч ч нэгэн адил сурвалж хэрэглэгдэхүүн ашигласан, тэдгээр сурвалж хэрэглэгдэхүүн нь “Судрын чуулган” зэрэг 3 эх сурвалжид ашигласантай нэг гаралтай буюу төдий л ялгаагүй зүйл байсан болов уу. Тийнхүү үзэх болсон үндэслэлийг дараах зүйлд өгүүлье¹¹.

2.”Нууц товчоо”-г эмхэтгэгч сурвалж материалуудыг өөрчилсөн нь

Дээр өгүүлсэн зүйлийг доорх 2 жишээн дээр авч үзье.

2.1 Хүйтэний байлдаан

“Нууц товчоо”-нд гарах “Хүйтэний (Köyiten) байлдаан”-ы гол агуулга дараах мэт.

(a) Тахиа жил (1201 он)

(b) Qatagin, Salji’ud, Dörben, Tatar,

10. [Yoshida 1968: 48-49, 53]. Үлгэр түүхчийн ой санамжийг ”Нууц товчоо”-г эмхэтгэхэд ашигласан тухайд Бира, Ринчин нар мөн нэгэн адил саналтай байна [Бира 1978:41; Irinčin 1987: 36, 85].

11. 2010 оны 11 сард Монгол улсад болсон “Монголын нууц товчоо”-ны 770 жилийн ойд зориулсан олон улсын эрдэм шинжилгээний хуралд тавьсан илтгэл.

(c) Onggirad,

(d) Ikires, Qorolas,

(e) Naiman, Merkid, Oyirad,

(f) Тайи́и'ud –ийн хүмүүс,

(g) Alqui bulay-т цуглаж,

(h) Jadaran-гийн Jamuq-ийг qa(n)-нд өргөмжлөө хэмээн,

(i) адуу алж тангараглан,

(j) Ken müren Eгүне müren-д цутгах цутгаланд нүүсний хойно, Gür qa(n)-д өргөмжилж, Temüjin болон Ong qan-ыг довтолсон боловч Qorolas-ийн Qoridai-н мэдээг авч Temüjin Ong qan-д байдлыг мэдэгдэв.

(k) Temüjin болон Ong qan цэрэг авч Көyитен-д тулгарах үед Naiman-ы Buyiruc qan болоод Oyirad-ын Quduqa beki нар jada хэрэглэсэн боловч ялагдаж,

(l) Jamuqa өөрийг нь qan-д өргөмжилсөн иргэдийг дээрэмдэн зугатаж,

(m) Түүнийг Ong qan нэхэв.

(n) Temüjin, Тайи́и'ud-ыг нэхэж, Onan müren-ий орчим Hüle'üd turas-д халз тулалдан, Тайи́и'ud-тай отолцож хоноглоход тэд шөнөөр зайлан зугатав.

(o) Temüjin энэ байлдаанд шархдсаныг Jelme асрав.

(p) Маргааш өдөр Suldus-ийн Sorqan šira болон Qada'an, Besüd-ийн Jebe ирж дагав.

(q) Temüjin тэр үед, A'ucu ba'atur, Qodun Örcen, Qudu'udar нарын Тайи́и'ud-ыг хүйс тэмтэрч, тэдний ulus irgen-ийг хураав.

(r) Ničügüd Ba'arin-ий Širgü'etü болон хүү Alaq, Naya'a нар өөрсдийн поу-ан болох Тайи́и'ud-ийн Tarqutai kiriltuq-ийг барьсан боловч суллаж, улмаар Чингисийн дэргэд ирж дагав.

Харин “Судрын чуулган” зэрэг 3 сурвалжид “Нууц товчоо”-нд “Хүйтний байлдаан”-д хамруулан тэмдэглэсэн үйл явдлыг доорх (E)-д дурдсанчлан “Хүйтний байлдаан”-аас өмнө болсон хэд хэдэн үйл явдал мэт бичжээ. Тэдгээрийг он дараалалаар нь жагсаавал, (A), (B), (C), (D) болно. Эдгээр (A)-(E)-д тэмдэглэгдсэн үйл явдал нь “Нууц товчоо”-ны Хүйтний байлдааны аль хэсэгт холбогдож буйг (A)-(E)-гийн ард [] хаалтанд (a), (b), (c)...гэх мэтээр тэмдэглэвэл дараах мэт.

(A) Temüjin-ий дэргэд Тайи́и'ud-ын харьяат нар ирж, түүнд дагав. (“Судрын чуулган”-д 1194 оноос өмнө болсон гэж буй) [(p),(r)] .

(B) Temüjin, Ong qan хоёр Тайи́и'ud-ыг довтолж сөнөөсөн. (“Судрын чуулган”-д 1200 оны үйл явдал хэмээсэн) [(n),(q)] .

(C) Qatagian, Salji'ud, Dörben, Tatar, Тайи́и'ud” нарын Alqui bulay-т

тангараг тавьсан, Бууц нуурын байлдаан ("Судрын чуулган"-д 1200 оны явдал хэмээсэн) [(b), (c), (g), (i)] .

(D) Onggirad, Ikires, Qorolas, Dörben, Tatar¹², Qatagin, Salji'ud нар Jamuqa-ыг Gür qa(n)-д өргөмжилсөн, Idi qurqan-ны байлдаан ("Судрын чуулган"-д 1201 оны явдал хэмээсэн) [(b), (c), (d), (h), (j)] .

(E) Хүйтний байлдаан ("Судрын чуулган" зэрэг 3 сурвалжид энэ үйл явдлыг 1202 онд болсон хэмээсэн) [(a), (b), (e), (f) ?, (k), (l)] .

Үүнээс үзэхэд, "Нууц товчоо"-нд тахиа жил болсон гэх Хүйтний байлдаанд хамаарах үйл явдал (a)-(г) –ыг "Судрын чуулган" зэрэг 3 сурвалжид хэдэн жилийн ("Судрын чуулган"-нд 1194, 1200, 1201, 1202 он, "Тэмдэглэл" болон "Юан улсын судар"-т мөн хэдэн жилд болсон хэмээсэн) турш болсон хэмээх (A)~(E)-гийн үйл явдалтай олон талаар холбогдож байгааг мэдэж болно. [Yoshida 1992; Yosida 2005; Yoshida 2009 b].

"Нууц товчоо"-нд гагц тахиа жилд болсон гэх Хүйтний байлдаанд холбогдох үйл явдал (a)-(г)-ыг "Судрын чуулган" зэрэг 3 сурвалжид хэд хэдэн жил буюу дээр дурдсан (A)~(E)-гийн 5 удаагийн үйл явдалд салгаж хуваах боломжтой юу? Тийм боломжгүй. Харин түүний эсрэг хувилбар байж болох юм. Өөрөөр хэлбэл, "Нууц товчоо"-г засварлаж бичсэн хүн "Судрын чуулган" зэрэг 3 сурвалжийг бичихэд ашигласантай нэг гаралтай буюу ойр төрлийн сурвалжийг ашиглан дээр дурдсан шиг Хүйтний байлдааныг дүрслэн бичсэн байж болох юм.

Ер нь "Нууц товчоо" дахь Хүйтний байлдаан нь Чингис болон Он хааны хүчний эсрэг Монголын тал нутгийн ихэнх нүүдэлчин аймгууд нэгдэж Жамухыг Гүр хаанд өргөмжлөн тэмцэж, Жамухын тал ялагдсан явдал авч гагц "Нууц товчоо"-г хичнээн уншлаа ч хэтэрхий гэнэтийн бөгөөд тухайн үед зүг зүгээс олноор ирж нэгдэн Он хаан, Тэмүүжиний эсрэг тэмцэх болсон шалтгаан нь ч тодорхойгүй байна.

Хэдий тийм боловч "Судрын чуулган" зэрэг 3 сурвалжид тэмдэглэсэн үйл явдал болох (A)-(E)-г шинжилж үзвэл, тэдгээр нь Чингис буюу Чингис хийгээд Он хааны монголын тал нутгийн дорнод зүгийн аймгуудыг эрхшээлдээ оруулах гэсэн эдрээтэй үйл явцтай холбоотой байсныг ойлгож болно. Үүнийг "Нууц товчоо"-нд Чингисийн Татарыг дарсанаас (татарууд мөн монголын тал нутгийн зүүн хэсэгт байсан) бусад үйл явдлыг тахиа жилд эхэлж тэр ондоо дууссан мэтээр нэгтгэн бичсэн байна [Yoshida 1992; Yoshida 2009b]. Өөрөөр хэлбэл, "Нууц товчоо"-ны тэмдэглэл учир зүйд эс нийцэх бөгөөд үүний цаана эмхэтгэгчийн хүчээр эмхэтгэх санаа оршиж байсан гэж үзэхээс өөр арга үгүй.

12. "Tatar" нь "Судрын чуулган"-ы Смирновагийн орос орчуулга "Рашид ад дин, Сборник летописей, Том 1-2, 1952. Москва. p.120)-д дурдагдаагүй. Харин Березин нарын Перс хэлээрх эх болоод "Тэмдэглэл"-д дурдагддаг.

Мөн Чингис болон Хэрэйд аймгийн харилцааны тухайд ч үүнийг харж болно. Тухайлбал, “Судрын чуулган” зэрэг 3 сурвалж дотроос “Судрын чуулган”-ыг дагах ахул, 1195 оны урд жилээс эхлэн 9 жилийн турш болсон ээдрээтэй үйл явдлыг “Нууц товчоо”-нд 1201 оноос өмнөх явдлыг эргэн дурсах аргаар ердөө 1201-1203 оны хооронд гурван жилд хураангуйлсан байдаг[Yoshida 1968; Yosida 2005]. Энэ мэт “Судрын чуулган” зэрэг 3 эх сурвалжийн эмхэтгэгч “Нууц товчоо”-г эмхэтгэхэд ашиглагдсан сурвалжийг ашиглаж тэр мэт үйл явдлыг ээдрээтэй байдлаар хувааж бичихэд бэрх тул, “Нууц товчоо”-г эмхэтгэгч нь дээрх 3 сурвалжид өгүүлсэнчлэн ээдрээтэй олон үйл явдлыг цэгцэлж бичсэн хэмээн санана.

Тийнхүү “Судрын чуулган” зэрэг 3 сурвалжид хэдэн жилийн туршид болсон ээдрээтэй үйл явцын дүнд Чингисийн зүгээс түүнд дайсагнах аймгуудтай харьцаа буюу тэмцлийг “Нууц товчоо”-нд богино цаг хугацаанд дараалан болж өнгөрсөн бүлэг үйл явдал болгон бичсэн гэвэл чингэсэн шалтгаан нь “Нууц товчоо”-г эмхэтгэгчийн хүсэл зориг буй за. Өөрөөр хэлбэл, “Нууц товчоо”-г бичихэд ашигласан сурвалж хэрэглэгдэхүүний агуулгыг эмхэтгэгч өөрийн үзэл зоригт тааруулж өөрчлөн бичжээ. Чингэхдээ түүний ашигласан сурвалж хэрэглэгдэхүүн нь “Судрын чуулган” зэрэг 3 сурвалжийг бичихэд ашиглагсантай нэг гаралтай буюу ойр төрлийнх байх магадлал өндөр мэт.

2.2 Он хан болон Чингис хааны эцэг хүүгийн холбооны тухай

“Нууц товчоо”-нд Чингис Бөртэг эхнэрээ болгон авч, Он ханд золгохоор очиход тэрбээр Чингисийн эцэгтэй анд бололцсон байсан учраас Чингисийг хүү хэмээн дуудсанаар эцэг, хүү бололцсон тухай өгүүлдэг. Энэ явдлыг “Судрын чуулган”-ы “Чингис хааны өвөг дээдсийн тэмдэглэл” зэрэгт мөн дурдсан буй [Yoshida 1996; Yosida 2005].

“Судрын чуулган” зэрэг 3 сурвалжаас үзвэл, түүний дараа Он хан Хэрэйдийн дотоодын зөрчлийн улмаас Хар Хятадад зугтсан авч ядарч доройтон эргэж ирэхэд Чингис түүнд тусалсанд талархан эцэг хүү бололцсон аж (“Судрын чуулган”-д үүнийг 1196 онд болсон гэжээ). Гэтэл “Нууц товчоо”-нд Чингис Он ханыг тусалсаныг 1201 оны үйл явдлыг эргэн дурсах хэлбэрээр өгүүлсэн атал эцэг хүү бололцсон тухай дурдсангүй. Улмаар дараа жилийн 1202 онд Он хан Чингисийн хамт Найманы Хүгсүү Сабрагтай тулалдах үед шөнөөр цэргээ татаж, Чингисийг хүнд байдалд оруулсан, удалгүй хүү Сэнгүмийн хамт Хүгсүү сабрагт тонуулж Чингисээс тусламж хүсч аврагдсан учраас Он хан түүнд талархаж, эцэг хүү бололцож, тулалдаан хийгээд ан авд хамт явах, дайсны өдөлт, хатгалганд автахгүй хэмээх утга бүхий андгай тавьжээ. Гэтэл “Судрын чуулган” зэрэг 3 сурвалжид энэ тухай тэмдэглэсэн (“Судрын чуулган”-д 1199 онд болсон) авч эцэг хүү бололцсон тухай дурдсангүй.

Энэ мэт “Нууц товчоо” болон “Судрын чуулган”-ы зөрүү ямар утгатай вэ? Үүнд хариулахад, Чингис Он хантай Халхалжид байлдсаны дараа Түнгэ голоос элч явуулж Он хан, Жамуха нарыг зэмлэсэн тухай “Нууц товчоо”-нд буй. Үүнд, Хар Хятадаас ядарч доройтон эргэж ирсэн Он ханыг Чингис туслах үед тэд эцэг хүү бололцсон гэжээ. Мөн Хүгсэү сабрагт тонуулсан Он хан, түүний хүүг Чингис тусалсан тухай дурдсан атал тэр үед эцэг хүү бололцсон дуудсан тухай эс дурджээ.

Энэ явдал юуг харуулж байна гэвэл, ”Нууц товчоо”-г эмхэтгэхэд ашигласан сурвалжид Хар Хятадаас доройтоод ирэхэд нь тусалсан Чингистэй Он хан Хар түний газар эцэг хүү бололцсон гэсэн авч “Нууц товчоо”-ны эмхэтгэгч тэр хэсгийг хасч, харин Хүгсэү Сабрагийн Он хан, түүний хүүг довтлон дээрэмдсэн, улмаар тэднийг Чингис тусалсан тухай өгүүлсэн хэсэгт шилжүүлэн оруулжээ. Гэвч Чингис Он ханыг зэмлэсэн үгийн дотор дурдагдах, Он хан Хар Хятадаас ядарч доройтон харьж ирсэний дараа Чингистэй эцэг хүүгийн андгай тавьсан гэдгийг хасахаа мартсан бөгөөд Хүгсэү Сабрагийн довтолгооноос Он хан нарыг аврах үед эцэг хүү бололцсон хэмээн нэмж оруулахаа мартсан тул Чингис Он ханыг зэмлэсэн үгийн дотор “Нууц товчоо”-г эмхэтгэхэд ашигласан сурвалжид бичигдсэн тэр хэвээр үлдсэн хэмээн үзэж болно [Ёшида 1993; Yosida 2005; Ёшида 2009a]. Юу гэвэл, “Нууц товчоо”-ны эмхэтгэгч 1201, 1202 онд болсон үйл явдлыг тодорхой шалтгааны улмаас засаж бичсэн нь тодорхой байна.

Дээрх (1), (2)-р зүйлийг нэгтгэн дүгнэвэл, “Нууц товчоо” болон “Судрын чуулган” зэрэг 3 сурвалжийн агуулга зөрүүтэй байгаа нь “Нууц товчоо”-ны эмхэтгэгч өөрчлөн бичсэнтэй холбогдох магадлал маш өндөр бөгөөд “Нууц товчоо”-г бичихэд ашигласан эх сурвалж нь “Судрын чуулган” зэрэг 3 сурвалжид ашигласантай үнэндээ бол нэг гаралтай буюу ойр төрлийн эх сурвалж байсан мэт.

3. Чингис хааны Жамуха болон Он хантайх харьцааг “Нууц товчоо”-нд хэрхэн өгүүлсэн тухай

“Нууц товчоо”-г эмхэтгэгч дээр дурдсан мэт өөрчлөн бичсэн гэвэл, “Нууц товчоо”-ны өөр олон газар засвар оруулсан байх магадлал өндөр юм. Тийм учраас энд сурвалж хэрэглэгдэхүүнийг засаж өөрчилсөн нь нэгэнт тодорхой болсон Чингисийн Жамуха болон Он хантайх харьцаагаар авч үзье.

“Нууц товчоо”-нд Бөртэ үжинг мэргэдүүд булаан авахад Чингис Хэрэйдийн Он ханаас тусламж, Он хан Жамухаас хамтрахыг хүссэнээр гурвуул нийлж их цэрэг хөдөлгөж Бөртэг эргүүлж авдаг.¹³

13. Тийм том хэмжээний тулалдаан үнэхээр болсон бол “Судрын чуулган” зэрэг 3 сурвалжид дурдах ёстой байтал тулалдааны талаар ер дурдалгүй, Мэргидүүд булаан авсан Бөртэг дараагаар Он ханд илгээж, Он хан Чингисийн эцэг Есүхэйтэй анд барилдсан төдийгүй Чингисийг хүү хэмээн дууддаг байсан тул Бөртэ үжинг өөрийнх болгож авалгүй Тэмүжинд өгсөн гэснээс өөр зүйлгүй. (“Судрын чуулган”-ы овог аймгийн бүлэг, Жалайр овгийн зүйл. Рашид-ад дин 1952.) Энэ байлдааныг “Тэмдэглэл” болон “Судрын чуулган”-

Түүний дараа Чингис Жамухатай хамт нутаглаж, урьд нь 11 настайгаас хойш 2 удаа тавьсан андын тангарагыг дахин тавьж, шөнө нэг хөнжилд унтсан гэж буй. Үүгээр тэр хоёрыг андын тангаргыг 3 удаа тавьж, хатуу барилдлагаар барилдсан гэдгийг илэрхийлж байна. Гэтэл жилийн дараа зусланд нүүх үеэр Жамуха үл ойлгогдох зүйл хэлсэнээс болж Чингис түүнийг сэжиглэж, аюулаас сэргийлэхийн тулд Жамухаас холдсон аж.

Чингис Он ханы хувьд, Он хан Чингисийн эцэг Есүхэйн анд байснаас үүдэн Чингис Бөртэ үжинг эхнэр болгон авсан, бас нохой жил (1202 он) Чингис Хүгсэү сабрагаас Он хан түүний хүү Сэнгүмийг аварсан үед 2 удаа эцэг хүү хэмээн дуудалцаж (Есүхэйтэй тогтоосон андын холбоог тооцвол, Он хан Есүхэй болон Чингисийн урагтай тогтоосон 3 дахь удаагийн барилдлага болно), 2 дахь удаа андгай үг тавьсанаар тэдний барилдлага илүү бат бэх болов.

Гэтэл удалгүй Чингис Он ханыхантай тогтоосон барилдлагаа бэхжүүлэхийн тулд Он ханы хүү Сэнгүмийн охиныг ахмад хүү Жүчид эхнэр болгон авч өгөх гэтэл Сэнгүм татгалзаж, тийнхүү тааламжгүй болсон байдалд Жамуха хөндлөнгөөс оролцсоноор Чингис, Он хан хоёр тулалдсан ажээ.

Чингэвэл дээр дурдсанчлан “Нууц товчоо”-нд Он хан, Чингис нар 2 дахь удаа эцэг хүү бололцсон нь Хар Хятадаас доройтоод эгэж ирсэн Он ханыг Чингис тусалсан тэр үед биш, түүнээс хойно (“Судрын чуулган”-нд 3 жилийн дараа гэсэн) Чингис Хүгсэү сабрагийн довтолгооноос Он хан нарыг аварсан үед гэсэн буй. Тийнхүү болсон явдлыг өөрчилж бичих болсон шалтгаан нь хоёр этгээдийн харьцаа муудаж хагарал гарахын өмнөхөн хүртэл сайн харьцаатай байсан атал муудах нөхцөл байдлыг үүсгэсэн Он ханыг буруутган харуулахад оршиж байсан нь лавтай.

Мөн Чингис Он хан хоёрын хатуу барилдлага эвдэрсэн явцыг Чингис Жамуха хоёрынхтой адилтгах гэсэн нь тодорхой юм.

Хэрэв тийм бол Чингисийн Жамуха болон Он хантай эвдрэлцсэнээс хойших тулалдааны талаар нэгэн адил үйл явц болсон байх учиртай мэт санагдана. Үнэхээр Чингисийн Жамуха болон Он хантай хийсэн тулалдаан тус бүр 2 удаа болж, эхний удаад тэр ялагдаж 2 дахь удаагийн тулалдаанд ялсан гэж бичигджээ. Тухайлбал, Жамухатай хийсэн эхний тулалдаан хоёр талаас 13 хүрээ бүхий 3 түмэн цэрэг оролцож, Далан Балжудад болсон бөгөөд үүнд Чингис ялагдсан боловч дараагийн удаа Хүйтэний байлдаанд ялсан гэжээ.

Он хантай хийсэн тулалдаан гэвэл, Халахалжийн эхний тулалдаанд мөн л Чингис ялагдаж, хоёрдахь удаагийн Жэжээр Өндөрийн тулалдаанд Он ханыг шөнөөр довтолж ялсан гэж буй.

нд дараа жил нь буюу могой жил (1197 он) болсон гэх санал буй (Murakami 1970;196) боловч ямар ч үндэслэлгүй болно.

Гэтэл “Нууц товчоо”-нд Жамухатай хийсэн анхны тулаанд Чингис ялагдсан гэх атал “Судрын чуулган” зэрэг 3 сурвалжид дурдагдах бүхий л байлдаанд Чингис ялдаг. Угтаа Чингисийн ялагдлыг дурдахаас цээрлэх ёстой атал чухам ялагдсан хэмээн бичсэн учраас “Нууц товчоо”-ны агуулгыг бодитой хэмээн судлаачид үзэж ирэв [Нака 1907; Grousset 1941; Pelliot, Hambis 1951; Мураками 1970-1976; Жагчидсэцэн 1979 зэрэг].

Гэвч дээр өгүүлсэнчлэн “Нууц товчоо”-г зоримоогоор эмхэтгэсэн бичсэн зохиогчийн байр суурийг олж мэдвэл, “Нууц товчоо” түүхэн үнэнийг өөрчилж, Жамухад ялагдсан хэмээснийг тайлбарлаж болох мэт. Тулалдааны дараа Жамухын талаас Урууд, Мангуд, Хонготан зэрэг томоохон аймгийн иргэд Чингисийг дагасан хэмээсэн нь үнэхээр тэгсэн ч байж болох юм.

Чингэж үзвэл, Чингис, Он хан, Жамуха гурав хүч хавсран Мэргидээс Бөртэ үжинг эргүүлж авсан тулалдаан гэдэг нь тэд өмнө нь найрамдалт харилцаатай байсныг зориуд харуулахын тулд “Нууц товчоо”-ны эмхэтгэгч зохиож бичсэнээс гарцаагүй юм.¹⁴ Улмаар Жамуха Чингистэй андын холбоо, Он хан Чингистэй эцэг хүүгийн тангараг тавьсан хэдий боловч тэд өөрсдөө тавьсан тангаргаа зөрчсөн учраас л Чингис аргагүйн эрхэнд тэдэнтэй тэмцэж, тулалдсан. Тэгэхээр Чингисийн зөв гэдгийг цохон тэмдэглэхийн тулд “Нууц товчоо”-г өөрчлөн бичсэн болов уу.

“Нууц товчоо”-нд Жамухыг Чингисийн дайсан биш, өрсөлдөгч гэсэн байдлаар бичжээ. Тэр нь Чингис Хэрэйдийн Он хан, Наймны Даян ханыг мөхөөсний дараа ялагдсан Жамухаг Чингисийн өмнө авчирч, нүүр тулах үеэр түүний хоёр гавьяаг дурдаж дахин анд боллоцоё хэмээхэд Жамуха өөрийг нь хороохыг хүссэнд аргагүй түүний нэг гэм бурууг дурдаж цаазлах шалтгаан болгосноос тодорхой харагдана. Энд тухайлан эс өгүүлэх авч Чингисийн Жамухад хандаж хэлсэн үгийг “Нууц товчоо”-ны эмхэтгэгч зохиосон гэдэг нь тодорхой.

4. “Нууц товчоо”-г сурвалжийн хувьд үнэлэх нь

Дээр дурдсанчлан олон судлаач “Нууц товчоо”-г *Tobčiyān*-той адил, “Судрын чуулган” зэрэг 3 сурвалжийн үндэс болсон сурвалж гэж үзэж ирэв. Үүнд, “Нууц товчоо”-ны эх үндэс болсон *Činggis Qahan-u huja’ur*-ыг “Судрын чуулган” зэрэг 3 сурвалжийн эхлэл мөн гэж үзсэн Hung 1951-ийн байр суурийг ч дээрхтэй адилтгаж болно.

Гэтэл дээр өгүүлсэнчлэн “Нууц товчоо” нь “Судрын чуулган” зэрэг 3 сурвалжийн үндсэн сурвалж байх боломжгүй. Харин “Нууц товчоо”-г эмхэтгэгчийн гарын дор байсан сурвалж хэрэглэгдэхүүн нь “Судрын чуулган” зэрэг 3 сурвалжийг бичихэд ашигласан хэрэглэгдэхүүнтэй адил буюу ойр харьцаатай сурвалж байсан, чухам тэр хэрэглэгдэхүүнийг ашиглаж “Нууц товчоо”-г эмхэтгэн бичсэн гэж үзэх нь зүйд нийцнэ.

14. Мөн дээрх.

“Нууц товчоо”-г эмхэтгэхдээ тэрхүү сурвалжийг үндсэн сурвалж болгон ашиглахын зэрэгцээ Чингис хааны шударга байдал, нэгдсэн улс байгуулахыг зөвтгөхийн тулд зориуд уг эхийг засаж өөрчилж, мэргэн үг, зүйр цэцэн үг, домог, шүлэг зэргийг ашиглаж, уран яруу дүрслэл, дур сонирхол татам агуулга бүхий болгожээ.

Тэр үеийн үлгэр түүхийг хүүрнэн дамжуулагч нь тухайн аймаг, бүлэглэл хоорондын харьцааг цээжилж ярихад хялбар, нэгтгэсэн байдлаар ярьж үлдээснийг эмхэтгэгч нэгтгэн цуглуулж он тоололын дагуу байрлуулж, утгыг авцалдуулж, илэрхийлэх санааг тодотгох үйл явдал нэмж оруулах аргаар бүтээсэн гэж таамаглах боломжтой нь Тобсйуан бөгөөд “Нууц товчоо” нь Тобсйуан дээр тулгуурлан монгол хэлээр бичсэн Магад хуулийн ноорог эх зэрэг хэрэглэгдэхүүнийг үндсэн сурвалж болгон эмхэтгэсэн, чингэхдээ Чингисийн байр сууринаас нэгдсэн улс байгуулах явц дахь түүний шударга, зөв зүйтэй чанарыг тодоор илэрхийлсэн мэт.

Харин “Нууц товчоо” болон “Судрын чуулган” зэрэг 3 сурвалжийг эмхэтгэхэд ашигласан сурвалж хэрэглэгдэхүүний харьцаа холбооны тухайд, цаашид дахин хянан судалж үзэх шаардлага буйг тэмдэглэвээс зохионо.

Дүгнэлт: “Нууц товчоо” судлалын ирээдүй

Ёшида, Окада нар “Нууц товчоо”-г түүхийг тэмдэглэсэн эсэхэд эргэлзсэн санал дэвшүүлсэнээс хойш Японы Монголын түүх судлаачийн олонх нь “Нууц товчоо” ялангуяа Монголын эзэнт улс байгуулагдах хүртэлх “Чингисийн шастир”-ийн тухайд түүх судлалын үүднээс хөндөхөд болгоомжтой хандах болсон бөгөөд олон нийтэд зориулсан түүхийн ном зохиолд ч 1206 онд нэгдсэн улс байгуулах хүртэлх үйл явцын талаар тодорхой өгүүлдэггүй. “Чингисийн шастир”-ийн тухай асуудлаар түүхийн үүднээс судалсан миний хэдэн судалгаа [Ёшида 1986; 1993; 1996; Yosida 2005]-наас өөр судалгаа үгүй гэж хэлж болохуйц байлаа.

Энэ хооронд “Судрын чуулган”-ы судалгаанд ахиц гарч, Оросод тайлбар зүүлт бүхий эх хэвлэгдэхийн өмнөхөн Амбис бээр “Судрын чуулган”-ы судалгаа хангалтгүй учраас “Алтан дэвтэр”-ийг бүрэн ойлгоход бэрхтэй гэж шүүмжлэх [Pelliot, Hambis 1951] удаа байсан ч ойрын хэдэн жилд “Судрын чуулган”-ы судалгааны түвшин ахиж, байдал ихээхэн өөрчлөгдөж байна. Миний сүүлийн үеийн “Алтан дэвтэр”-ийн судалгаа ([Yosida 2005]-д орсон) нь “Судрын чуулган”-ы хувилбаруудын талаарх сүүлийн үеийн судалгааны үр дүнг тусгасан бөгөөд энэ тал дээр Чингисийн эхийн өсгөсөн өргөмөл хүүхдүүд болон Чингис анх хаан ширээнд өргөмжлөгдсөн тухай судалсан Үногийн [Үно 2009] судалгаа ч нэгэн адил болно.

“Судрын чуулган”-ы судалгааны үр дүнг тусгах замаар “Нууц товчоо”-ны судалгааг урагшлуулах нь цаашид “Нууц товчоо” судлалын нэг арга болно.

Дээр дурдсанчлан, “Нууц товчоо” нь “Судрын чуулган” зэрэг 3 сурвалжийн нэгэн адил Монголын эзэнт гүрэн байгуулагдсан үйл явцыг өгүүлэх нь асуудал үгүй мэт санагдана. Гэвч “Судрын чуулган” зэрэг 3 сурвалжид өгүүлэх зүйлийг бүгд үнэн гэж үзэж болохгүй, зарим тохиолдолд “Нууц товчоо” илүү тодорхой өгүүлсэн нь ч буй. Энэ мэт нөхцөлд “Нууц товчоо”-г судлахад, тус өгүүлэлд авч үзсэнчлэн “Нууц товчоо” чухам юу хэлэх гэсэн, юу өгүүлсэн, хэрхэн дүрсэлсэн зэргийг ухаж ойлгохын сацуу “Судрын чуулган” зэрэг 3 сурвалжтай харьцуулж судлах шаардлагатай болов уу.

Abstract: Among the sources of the Mongol Empire written almost in the milieu of the same period, namely the Secret History of the Mongols, the Description of the Personal Campaigns of the Holy Martial, the Yuan shi and the Compendium of the Chronicles by Rashid al-Din stand as the core ones. The comparative study of these sources in terms of content and correlation to each other is essential. Particularly, the study of the Secret History of the Mongols shows that it differs from the other three sources by its structure. The reason for this is not a usage of different sources at the hand of authors, but principle ideas of the author of the Secret History of the Mongols.

Ном зүй.

Япон хэлээр

Uemura 1931: 植村清二「元朝秘史の奥書に就いての疑問」『史学雑誌』42-7

Narayama 1978: 原山 煌『元朝秘史関係文献目録』東京, 日本モンゴル学会

Hattori 1946: 服部 四郎『元朝秘史の蒙古語を表はす漢字の研究』東京, 龍文書局

Ishihma 1935: 石濱 純太郎「元朝秘史考」『龍谷史壇』15

Kobayashi 1941: 小林高四郎『蒙古の秘史』東京, 生活社

Kobayashi 1954: 小林高四郎『元朝秘史の研究』東京, 日本学術振興会

Kuribayashi, Čoyijinjāb 2001: 栗林 均, 確精扎布『『元朝秘史』モンゴル語全単語・語尾索引』仙台, 東北大学

Morikawa 2007: 森川 哲雄『モンゴル年代記』福岡, 白帝社

Murakami 1970-1976: 村上 正二『モンゴル秘史』1-3, 東京, 平凡社

Naka 1907: 那珂 通世『成吉思汗実録』東京 大日本図書株式会社(再:1943. 東京, 筑摩書房)

- Okada 1985:岡田 英弘「元朝秘史の成立」『東洋学報』66-1・2・3・4
- Ozawa 1954:小澤 重男『中世蒙古語諸形態の研究』東京, 開明書院
- Ozawa 1984-1989:小澤 重男『元朝秘史全釈』上・中・下, 『元朝秘史全釈
続放』上・中・下, 東京, 風間書房
- Ozawa 1993a:小澤 重男『元朝秘史文法講義』東京, 風間書房
- Ozawa 1993b:小澤 重男『元朝秘史文法講義続講』東京, 風間書房
- Ozawa 1994:小澤 重男『元朝秘史』『元朝秘史』東京, 岩波書店
- Ozawa 1997:小澤 重男上下, 東京, 岩波書店
- Shiratori 1943:白鳥庫吉『音訳蒙文元朝秘史』東京, 東洋文庫
- Temürbayana 2009:トゥムルガバナ, B.「中国にある『元朝秘史』諸抄本に
ついて」(鈴木仁麗訳)『早稲田大学モンゴル研究所紀要』5
- Uemura 1955:植村 清二「元朝秘史小記」『東方学』10
- Uno 2009:宇野伸浩「チングス・カン前半生の研究のための『元朝秘史』と
『集史』の比較研究」『人間環境学研究』(広島修道大学)7
- Yoshida 1968 :吉田 順一 1968「元朝秘史の歴史性」『史観』78
- Yoshida 1984:吉田順一「『元史』太祖本紀の研究—特に祖先物語について
—」『中国正史の基礎的研究』東京, 早稲田大学出版部
- Yoshida 1986:吉田順一「タイチウト部衆の来属——『聖武親征録』・『集
史』・『元史』太祖本紀の比較検討」『アジア史における年代記の
研究』(文部省科学研究費研究成果報告書), 東京
- Yoshida 1993 :吉田順一「オン・カンとテムジンの後期の関係—父子を言い交わしたと
いう伝承の分析」『蒙古史研究』4, 呼和浩特
- Yoshdia 1996:吉田順一「テムジンとオン・カンの前期の関係—二人の父子
関係についての伝承の分析」南京大学元史研究室編『内陸亜洲歴史
文化研究—韓儒林先生紀念文集』
- Yoshida 2009a:吉田順一「『モンゴル秘史』研究」『早稲田大学モンゴル研
究所紀要』5
- Yoshida 2009b:吉田順一「クイテンの戦いの実像」『早稲田大学モンゴル
研究所紀要』5

Монгол хэлээр

- Гаадамба 1976:Гаадамба, Ш. , Нууц товчооны нууцсаас. Улаанбаатар
- Дамдинсүрэн 1957:Дамдинсүрэн, Ц. Монголын нууц товчоо. Улаанбаатар
- Дашцэдэн 1985:Дашцэдэн, Т. , Монголын нууц товчоо. Улаанбаатар
- Төмөрцэрэн 1990:Төмөрцэрэн, Ж. , Нууц товчооны учир. БНМАУын

- ШУА-ийн Мэдээ-2. Улаанбаатар
- Bayar 1981: Bayar, Mongγol-un niyuča tobčiyān, 1-3. Kōkeqota
- Čeringsodnam 1993: Čeringsodnam, D. Mongγol-un niyuča tobčiyān-u orčiγulg-a tayilburi. Begejing
- Čoyim-a 2007: Čoyim-a, S. , Mongγol-un niyuča tobčiyān kiged Mongγol surbalji bičig-ün sudulul. Kōkeqota
- Damdinsürüng 1947: Damdinsürüng, Č. , Mongγol-un niyuča tobčiyān. Ulaγanbayatur
- Eldengtei, Ardajab 1986: Eldengtei, Ardajab, Mongγol-un niyuča tobčiyān: seyiregölül tayilburi. Kōkeqota
- Eldengtei, Oyundalai, Asaraltu 1991: Eldentei, Oyundalai, Asaraltu, Mongγol-un niyuča tobčiyān-u jarim üges-ün tayilburi. Begejing
- Irinčin 1987: Irinčin, Y. , Mongγol-un niyuča tobčiyān. Kōkeqota
- Irinčin 2001: Y. Irinčin-ü Mongγol sudulul-un bütügel-ün čiγulyān(亦隣真蒙古学文集). Kōkeqota
- Jingkin 1991: Jingkin, Čaγ üy-e-yin tuqai jadalun sudulqu ni. , Mongγol-un niyuča tobčiyān"-u sudalyān. Kōkeqota
- Mongγol-un niyuča tobčiyān-u sudulyān 1991: Mongγol-un niyuča tobčiyān-u sudulyān, Öbür mongγol-un keblel-ün qoriy-a. Kōkeqota
- Qangyai 2004: Qangyai, Mongγol-un niyuča tobčiyān-u soyul sudulul. Kōkeqota
- Temürbayan-a 2004: Temürbayan-a, B. , Mongγol-un niyuča tobčiyān-u surbulji bičig ber keblel-ün sudulul. Kōkeqota
- Yosida 2005: Yosida, J. , Mongγol-un niyuča tobčiyān-u sudulul. Čenggel nar orčiγulba. Begejing

Хятад хэлээр

- Ardajab 2005: 阿爾達扎布『新訳集注《蒙古秘史》』, 呼和浩特
- Din 1901: 丁謙『元秘史地理考証』
- Dorunatib 1979: 道潤梯步1979『新訳簡注《蒙古秘史》』, 呼和浩特
- Eldengtei, Oyundalai, Asaraltu 1980: 額爾登泰, 烏雲達賚, 阿薩拉圖『《蒙古秘史》詞滙選釈』, 呼和浩特
- Eldengtei, Oyundalai 1980: 額爾登泰, 烏雲達賚『蒙古秘史校勘本』, 呼和浩特
- Jagčidsečen 1979: 札奇斯欽『蒙古秘史新訳並註釈』台北
- Jen 1986: 甄金「『蒙古秘史』源流研究概述」『蒙古史研究』2, 呼和浩特

- Li 1896:李文田『元朝秘史注』（叢書集成本）
 Ulayan 2012:烏蘭『元朝秘史（校勘本）』北京
 Yao, Jagčidsečen 1960-1962:姚從吾，札奇斯欽「漢字蒙音蒙古秘史新訊並註
 釈」『文史哲學報』9-11, 台北
 Yu 1982:余大鈞「蒙古秘史成書年代考」『中國史研究』第1期
 Yuanchao mishi 1975:『元朝秘史三種』京都

Англи хэлээр

- Cleavs 1982: Cleavs, F. W., *The Secret History of the Mongols*. Cambridge, Massachusetts
 Grousset 1941: Grousset, R., *L'empire mongol*. Paris
 Haenisch 1935: Haenisch, E., *Mangᡤol-un niuca tobca'an (Yüan ch'ao pi-shi): Die Geheime Geschichtete der Mongolen aus der chinesischen Transkription (Ausgabe Ye Têh-hui) im mongolischen Wortlaut wieder hergestellt*. Leipzig, 1935/1937[al]
 Haenisch 1941: Haenisch, E., *Die Geheime Geschichtete der Mongolen: Aus einer mongolischen Niederschrift des Jahres 1240 von der Insel Kode'e im Keluren-Fluss erstma lig übersetzt und erläutert*. Leipzig
 Heissig 1981: Heissig, W., *Die Geheime Geschichtete der Mongolen*. Düsseldorf/Köln
 Hung 1951: Hung, W. (洪煨蓮), "The Transmission of the Book Known as The Secret History of the Mongols." *Harvard Journal of Asiatic Studies*, 14
 Ligeti 1971: Ligeti, L., *Histoire secrète des Mongols*. Budapest
 Mostaert 1953: Mostaert, A., *Sur quelques Passages de l'Histoire Secrète des mongols*. Cambridge (Massachusetts)
 Okada 1970: Okada, H., *The Secret History of the Mongols, A Pseudo-historical Novel*. Proceedings of the Third East Asian Altaistic Conference, Taipei
 Pelliot 1949: Pelliot, P., *L'Histoire secrète des Mongols*. 1, Paris
 Pelliot, Hambis 1951: Pelliot, P., Hambis, L., *Histoire des Campagnes de Genis Khan, Introduction*. Tom 1, Leiden
 Pao 1965: Pao Kuo-yi, *Studies on The Secret History of the Mongols*. Bloomington
 Poucha 1956: Poucha, P., *Die Geheime Geschichtete der Mongolen*. Praha
 Rachewilts 1965: Rachewilts, I. De, "Some Remarks on the Dating of The

- Secret History of the Mongols.” Monumenta Serica, 24
- Rachewilts 1972:Rachewilts, I. De, Index toThe Secret History of the Mongols. Indiana, Bloomington
- Rachewilts 2004:Rachewilts, I. De, The Secret History of the Mongols. 2vols., Leiden-Boston
- Yoshida 1992:Yoshida, J., On the battle of Köyiten. Олон улсын Монголч эрдэмтний V их хурал, 1 боть, Улаанбаатар

Орос хэлээр

- Бира 1978:Бира, Ш. , Монгольская Историография (XIII-XVII вв.). Москва
- Владимирцов 1934:Владимирцов, В. Я. , Общественный строй монголов. Ленинград
- Козин 1941:Козин, С. А. , Сокровенное сказание монголов. Москва-Ленинград
- Палладий 1866:Палладий,П.И., Старинное монгольское предание о Чингис-хане (Сокровенное сказание о поколении поколении Монгол), Труды членов Российской духовной миссии в Пекине. Т. V. СПб.
- Панкратова 1962:Панкратова,В.И., Юань чао би-ши (Секретная история Монголов). Москва
- Рашид-ад дин 1952:Хетагуров,Л.А., Рашид-ад дин, Сборник летописей. Том 1, Москва /Ленинград

Энэхүү өгүүлэл нь, *”Монголын түүх судлал: Өнөө ба ирээдүй”*, Хянан хэвлүүлсэн Ёшида Жүн-Ичи, Васэда их сургуулийн Монгол судлалын хүрээлэн, 2011 он, Токио -д хэвлэгдсэн өгүүлийг нэмж зассан эх бөгөөд япон хэлнээс Л.Лхагвасүрэн орчуулж, О.Оюунжаргал хянав.